



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/172

Сүхбаатар сум

Түр хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", 29.2, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалт явагдахтай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 08.00 цагаас эхлэн 06 дугаар сарын 26-ны өдрийн 10.00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Сонгуулийн санал авах өдөр гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулах, соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахыг тус тус хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ